



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 07 сарын 04 өдөр

Дугаар А/1797

Чойр

Хөтөлбөр арга хэмжээний зардалд
өөрчлөлт оруулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, Төсвийн тухай хуулийн 14.2.2, Захиргааны ерөнхий хуулийн 45 дугаар зүйлийн 45.14, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2022 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн 08 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын 2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2022 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн А/73 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралтад тусгагдсан Аялал жуулчлалыг хөгжүүлэх арга хэмжээний зардлыг 11,000,000 (арван нэгэн сая) төгрөгөөр, Соёл урлагийг хөгжүүлэх арга хэмжээний зардлыг 40,000,000 (дөчин сая) төгрөгөөр, Орон нутгийн тусгай хамгаалалтын арга хэмжээний зардлыг 50,000,000 (тавин сая төгрөг) төгрөгөөр, Хоршоо, ахуйн үйлчилгээг хөгжүүлэх арга хэмжээний зардлыг 65,000,000 (жаран таван сая) төгрөг болгож тус тус өөрчилсүгэй.

2. Тус захирамжийн 2 дугаар хавсралтаар батлагдсан “Аялал жуулчлалыг хөгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 1.1.3, 1.1.4 дэх заалтуудын мөнгөн дүнд өөрчлөлт оруулж 1.1.3 дахь заалтад тусгагдсан арга хэмжээний зардлыг 1,200,000 (нэг сая хоёр зуун мянга) төгрөгөөр, 1.1.4 дэх заалтад тусгагдсан арга хэмжээний зардлыг 1,300,000 (нэг сая гурван зуун мянга) төгрөгөөр, Соёл урлагийг хөгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд 4.1 дэх заалт “Боржигин чуулгад уран бүтээл тууривахад дэмжлэг үзүүлэх” гэж нэмж, зардалд 20,000,000 (хорин сая) төгрөгөөр, Орон нутгийн тусгай хамгаалалтын арга хэмжээний төлөвлөгөөнд 14 дэх заалт “Батлан хамгаалах яамтай хамтран Говийн бүсийн 5 аймгийн сумдын Засаг даргын Тамгын газрын дарга нартай Цэргийн бэлтгэл сургалт явуулах арга хэмжээ” гэж нэмж зардалд 30,000,000 (гучин сая) төгрөгөөр, Хоршоо, ахуйн үйлчилгээг хөгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд 10 дахь заалт “Хөдөө аж ахуйн

хоршоологчдын холбооны улсын зөвлөгөөн зохион байгуулах” гэж нэмж зардалд 30,000,000 (гучин сая) төгрөгөөр тус тус хэрэгжүүлэхээр тусган өөрчлөн баталсугай.

3.Батлагдсан төсөв, төлөвлөгөөний дагуу ажлын удирдамж төсвийг батлуулан хэрэгжүүлж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын хэлтсийн дарга нарт даалгасугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Содном)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.БАТЗАМ